

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Үнэлгээний зорилго, арга зүй

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах ажлын талаар зөвлөмж боловсруулах замаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, гарсан дүгнэлт, зөвлөмжийг дараагийн бодлого, шийдвэр, төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталсан.

Тус хүрээлэнгийн 2024 оны үйл ажиллагааг дараах 5 бүлэгт хуваан үнэлгээ өгсөн. Үүнд:

- 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ
- 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ
- 3. Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ
- 4. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ
- 5. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ зэрэг болно.

Нэг.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1. “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт

Монгол улсын Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 1 зорилтын хүрээнд тус хүрээлэнгээс 2024 онд 4 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан.

Хэрэгжүүлсэн 4 арга хэмжээний биелэлтийг үнэлэхэд “үр дүнтэй” 100 хувьтай байна.

№	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/						Биелэлт /хувиар/
		100	90	70	50	30	0	
1.	4	4	-	-	-	-	-	100

/Биелэлтийг хавсралт №1-ээс үзнэ үү/

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.4.6, 4.4.7, 4.4.9 зорилтын хүрээнд 2024 онд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

№	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/						Биелэлт /хувиар/
		100	90	70	50	30	0	
1.	4.4.6	1	-	-	-	-	-	100
2.	4.4.7	2	-	-	-	-	-	100
3.	4.4.9	3	-	-	-	-	-	100
Нийт		6	-	-	-	-	-	100

/Биелэлтийг хавсралт №2-оос үзнэ үү/

Хоёр.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Хууль тогтоомж, тогтоолын дугаар	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэл /хувиар/					Биелэлт
			100	70	30	0	Хугацаа болоогүй	хувь
Монгол улсын хууль								
1	Статистикийн тухай /шинэчилсэн найруулга/ 1997_06_05	1	100	-	-	-	-	100
2	Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 30.2 2015-05-29	1	100	-	-	-	-	100
3	Хууль тогтоомжийн тухай хууль 45.3 /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29	1	100	-	-	-	-	100
Ерөнхийлөгчийн зарлиг								
4	Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017_07_10 2017_186	1	100	-	-	-	-	100
5	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018_46 2018_05_23	1	100	-	-	-	-	100
6	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60	1	100	-	-	-	-	100
7	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2	100	-	-	-	-	100
8	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	2	100	-	-	-	-	100

ҮАБЗөвлөмж								
9	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021_03 2021_09_30	1	100	-	-	-	-	100
Засгийн Газрын тогтоол								
10	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	1	100	-	-	-	-	100
11	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022_139 2022_04_06	2	100	-	-	-	-	100
12	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022_204 2022_05_25	1	100	-	-	-	-	100
13	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022_203 2022_05_25	4	100	-	-	-	-	100
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл								
14	оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 59 дүгээр тэмдэглэл 2020_59 2020_11_11	7	100	-	-	-	-	100
15	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022_11 2022_02_16	1	100	-	-	-	-	100
16	2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2022_21 2022_04_08	1	100	-	-	-	-	100
17	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022_28 2022_05_11	1	100	-	-	-	-	100
Монгол улсын ерөнхий сайдын албан даалгавар								
18	"Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" 2024_09_18 Дугаар 2024_01	1	100	-	-	-	-	100
Нийт			100	-	-	-	-	100

/Биелэлтийг хавсралт №3-аас үзнэ үү/

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 18 арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын үнэлгээг хийхэд биелэлт 100 хувь байна.

Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн хүрээнд статистик мэдээг 12 удаа, инфографик мэдээг 12 удаа албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гурав. Байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

	Үндсэн чиг үүрэг	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	
1	Стратегийн зорилт 1 Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн статус, үндсэн чиг үүргийг хуульчлан баталгаажуулж, түүнд нийцүүлэн байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн батлуулж, боловсон хүчний цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх	3	3	-	-	-	-	-	100
2	Стратегийн зорилт 2 Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны нэгдсэн сан бий болгох	2	2	-	-	-	-	-	100
3	Стратегийн зорилт 3 Хууль зүйн судалгаа шинжилгээний ажлын чанар, үр нөлөөг сайжруулах	5	5	-	-	-	-	-	100
4	Стратеги зорилт 4 Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, зүйлийг өргөжүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлэх	5	5	-	-	-	-	-	100
5	Стратегийн зорилт 5 Хууль зүйн албан бус сургалтын үйл ажиллагааг шат дараатай өргөжүүлэх	2	2	-	-	-	-	-	100
Нийт		17	17	-	-	-	-	-	100

Дөрөв. Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

4.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ

2024 оны төлөвлөгөөнд нийт 55 арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжүүлсэн байдлыг үнэлэхэд “үр дүнтэй” буюу хэрэгжилт 100 хувьтай байна.

Хариуцсан чиг үүргээр нь авч үзвэл:

	Үндсэн чиг үүрэг	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	
1	Үндсэн чиг үүрэг №1. /ХЗҮХ-ийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 1/	10	10	-	-	-	-	-	100
2	Үндсэн чиг үүрэг №2. хөгжүүлэх /ХЗҮХ-ийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 2/	1	1	-	-	-	-	-	100
3	Үндсэн чиг үүрэг №3. хөгжүүлэх /ХЗҮХ-ийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 3/	26	26	-	-	-	-	-	100
4	Үндсэн чиг үүрэг №4. хөгжүүлэх /ХЗҮХ-ийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 4/	14	14	-	-	-	-	-	100
5	Үндсэн чиг үүрэг №5. хөгжүүлэх /ХЗҮХ-ийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 5/	4	4	-	-	-	-	-	100
Нийт		55	55	-	-	-	-	-	100

4.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн үнэлгээ

2024 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн А/15 дугаар тушаалаар “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.2.1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх

Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2024 онд 12 удаагийн арга хэмжээний хүрээнд 34 удаагийн сургалтад алба хаагчдыг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 490 албан хаагч (1 алба хаагч дунджаар 11 сургалтад) хамрагдсан байна. Мэргэшүүлэх 19 сургалтад (давхардсан тоогоор) 143 алба хаагч хамрагдсан байна. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 2024 онд 21,213,500 сая төгрөг зарцуулсан байна.

Ажлаас гарсан 15, шинээр ажилд орсон 16, гадаадын их, дээд сургуульд магистр, докторантурт суралцаж байгаа 5, дотоодын их, дээд сургуульд магистрантурт суралцаж буй 7, докторантурт суралцаж байгаа 2, жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй 5 албан хаагч байна.

Холбогдох мэдээллийг хүний нөөцийн нэгдсэн системийн программд тухай бүр оруулсан байна.

4.2.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

1. Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардал байгууллагын нийт төсөвт 39,26 хувь, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд 17,1 сая төгрөгийн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, 5,3 сая төгрөгийн бичиг хэргийн хэрэгслээр ханган ажилласан.

2. 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/51 дүгээр тушаалаар албан хаагчдын өдрийн хоолны мөнгийг 27,000 төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс "Эрүүл амьдралын зөв дадал зуршил" сургалтын хүрээнд сэтгэл зүй, нойр, хоол зүй, дархлаа сэдвээр сургалт орж нийт 25 албан хаагч хамрагдсан. 2024.12.20-ны өдөр Эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн эмчийн зөвлөгөө мэдээллийг дотоод сүлжээнд байршуулсан. Албан хаагчдыг 2024.10.07-ны өдөр Төрийн албан хаагчдын эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. 2025 оны төсөвт албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн төсвийг 1 албан хаагчийн 200,000 төгрөг байхаар төлөвлөж хүргүүлсэн.

4. 2024 оны 1 дүгээр сард Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд байрлах шинээр баригдсан Эко интернэйшнл таурын 9 дүгээр давхарт түрээсээр байрлан албан хаагчдад ажиллах таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна.

5. Хоёр ажилтанд ар гэрийн гачигдлыг харгалзан үзэж буцалтгүй 2.700.000 төгрөгийн тусламж олгосон байна.

6. Албан хаагч бүрд орон сууц хөтөлбөрийн хүрээнд 30 албан хаагч Бриллиант партнер ХХК-ийн барьж буй орон сууцны барилгын төсөлд хамрагдаж хөнгөлөлттэй үнээр орон сууцны захиалгад хамрагдсан.

7. Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд тус хүрээлэнгийн 2023.05.18-ны өдрийн 01/211 тоот албан бичгээр амины орон сууцны зориулалт бүхий зуслангийн 0.07 га газрыг албан хаагчдын нэр дээр гаргуулах, холбогдох материалын хамт хүргүүлсэн.

	Үндсэн чиг үүрэг	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	
1	Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	4	4	-	-	-	-	-	100
2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	5	5	-	-	-	-	-	100
Дүн		9	9	-	-	-	-	-	100

/Биелэлтийг хавсралт №4-өөс үзнэ үү/

Тав.Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт

тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу хэрэгжилтийг гаргаж ил тод байдлын үнэлгээг гүйцэтгэлээ.

Байгууллагын www.nli.gov.mn цахим хуудсанд байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг, ажиллах цагийн хуваарь зэргийг тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан байна.

5.2. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд байгууллагын <https://nli.gov.mn> цахим хуудсанд 2024 онд сул орон тооны зарыг байршуулж, олон нийтийн сүлжээнд иргэдэд нээлттэй танилцуулсан.

Албан хаагчийн ёс зүйн дүрмийг www.nli.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэн ажилласан.

№	Нийт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/					Биелэлт /хувиар/
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт	9	9	-	-	-	-	100
2	Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	6	-	-	-	-	100
2	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны	11	11	-	-	-	-	100
3	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл	1	1	-	-	-	-	100
4	Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	2	-	-	-	-	100
	Нийт	29	28	-	-	-	-	100

/Биелэлтийг хавсралт №5 аас үзнэ үү/

5.3. Шилэн дансны мэдээлэл

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн вэб сайт www.shilendans.gov.mn-д төсөв, гүйцэтгэлийн чиглэлээр 71, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендерийн чиглэлээр 39, бусад чиглэлээр 61, нийт 28 чиглэлийн хүрээнд 171 мэдээ байршуулахаас 171 төрлийн мэдээг цаг хугацаанд нь байршуулсан, хэрэгжилт 100 хувьтай байна.

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн	Байршуулсан мэдээллийн төрөл	Тайлант хугацаан д байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан				Биелэлт /хувиар/
				100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	Төсөв, гүйцэтгэл	71	71	71	-	-	-	-	100
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	39	39	39	-	-	-	-	100
3	Бусад	61	61	61	-	-	-	-	100
	Дүн	171	171	171	-	-	-	-	100

Дүгнэлт

“Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлтийн биелэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажилласан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаанд 2024 оны байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Хувь
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. “Алсын хараа 2050”	100
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	100
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	100
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100
	2. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ	100
	3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100

	4. Шударга байдлын түвшний үнэлгээ	-
	5. Хэрэглэгчийн үнэлгээ	-
Нийт үнэлгээ:		100

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас , хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар хийдэг.

Санал, зөвлөмж

Үнэлгээг хийхдээ ХЗДХЯ-ны 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2024.03.14-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталж төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан.

3. Бодлогын баримт, бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа “нийтлэг журам”-ын 6.8-д заасны дагуу тайлагнасан.

4. Байгууллагын үйл ажиллагааны тайланг 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж мөн өдрийн 01/244 тоот албан бичгээр хүргүүлсэн.

5. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ,
ҮНЭЛГЭЭГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

ЗАХИРАЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ ТӨВИЙН ДАРГА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

ТАЙЛАНГ НЭГТГЭЖ, ҮНЭЛСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН



Х.ЭРДЭМ-УНДРАХ

М.ТҮВШИНЖАРГАЛ

Б.БААТАРЦОГТ

С.БИЛИГСАЙХАН

Н.УРАНЧИМЭГ

Г.МӨНХСУВД